# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр Дугаар 370 Улаанбаатар хот

Ховд аймгийн орон нутгийн өмчөөс
2018 онд хувьчлах эд хөрөнгийн
жагсаалтын тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн орон нутгийн өмчөөс 2018 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтын ёсоор дэмжсүгэй.

2.Жагсаалтад заасан эд хөрөнгийг хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хуулийн дагуу зохион байгуулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Пүрэвгандид зөвлөсүгэй.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б. Гаваа Б. ГАВАА

000217

D:\Huraldaanii material\2018 on\2018.09.04togtool.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 370 дугаар
тогтоолын хавсралт

## Ховд аймгийн орон нутгийн өмчөөс 2018 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалт

| д/д | Хувьчлах эд хөрөнгийн нэр | Эд хөрөнгийн олж авсан арга, хэлбэр, эрхийн акт, дугаар он сар өдөр | Байршил, Харъяалал | Хувьчлах эд хөрөнгийн үйл ажиллагааны чиглэл, үл хөдлөх хөрөнгийн зориулалт | Хувьчлагдах эд хөрөнгийн дүн /ААН бол нийт хөрөнгөөс өр төлбөр хассан дүнгээр, үл хөдлөх хөрөнгө бол балансын үлдэгдэл үнэ/ /мян.төг/ | Хувьчлах хугацаа | Хувьчлах арга, хэлбэр |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Үл хөдлөх эд хөрөнгө** | | | | | | | |
| 1 | Орон сууцны барилга | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Жаргалант сум Буянт баг, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар | Орон сууц | 81,852,000.0 | III-IV улиралд | Орон сууц хувьчлах тухай хуулийн дагуу |

---------- о О о ---------